

139

БНМАУ-ЫН СОЁЛЫН ЯАМНЫ КОЛЛЕГИ, УЛААНБААТАР
ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1988 оны 2 дүгээр
сарын 23 ны өдөр

Дугаар 25/245

Улаанбаатар
хот

Нийслэл Улаанбаатар хотын
эстрадын дуу бүжгийн чуулга
/музикхолл/ байгуулах тухай

МАХН-ын XIX их хурал, БНМАУ-ын Ардын Их Хурлын арван нэг дэх удаагийн сонгуулийн IY чуулганы шийдвэрийг хэрэгжүүлж төрийн байгууллагаас хөдөлмөрчдийн дунд зохиож буй соёл-олон түмний ажлын чанар, арга хэлбэр, үр нөлөө, уран сайхны соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх, хэрэглээний нэр төрлийг олшруулах, залуучуудын гоо сайхны боловсрол, хүмүүжлийг дээшлүүлж чөлөөт цагийг нь зүй зохистой өнгөрүүлэх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1987 оны 303 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийг үндэслэн БНМАУ-ын Соёлын яамны коллеги, Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Нийслэл Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны харьяанд хотын эстрадын дуу бүжгийн "Улаанбаатарын уянга" чуулга /музикхолл/-ыг 1988 оны 10 дугаар сарын 01-нээс эхлэн байгуулж ажиллуулсугай.

2. Эстрадын дуу бүжгийн чуулгын орон тоо, чалинг I дүгээр хавсралтаар, мөн сарын чалингийн фондыг 38,0 мян. тегрегеер баталсугай.

3. Эстрадын дуу бүжгийн чуулгад шаардагдах хөгжмийн зэмсэг, аппаратур хэрэгдэл, тайз гэрлийн тоног төхөөрөмж авах 200,0 мянга хүртэл тегрегийг хотын төсвийн орлогын төлөвлөгөө давуулж биелүүлсний шагналын хөрөнгөнөөс санхүүжүүлэхийг Хотын санхүүгийн хэлтэс /н. Гонгор/-т зөвшөөрсүгэй.

4. Тус чуулгад шаардлагатай зарим техник төхөөрөмжийг 1989-1991 оны дотоод, гадаад захиалгад оруулж өгөх арга хэмжээ авахыг Хотын төлөвлөгөөний комисс /н. Батбаяр/-т үүрэг болгосугай.

5. Эстрадын дуу бүжгийн чуулгын концертыг, төлбөртэй зохиогдох урлаг сурталчилгааны арга хэмжээний билетийн үнийг ялгавартайгаар баталж өгөхийг Хотын төлөвлөгөөний комисс /н. Батбаяр/, Үнэ, чанарын хэлтэс /н. Лхагвадорж/-т даалгасугай.

6. Нийслэл Улаанбаатар болон аймаг, хот, сум, САА-н хөдөлмөрчдэд урлагийн тоглолтоор явж үйлчлэх график телевизөөний дагуу шаардагдах унааны зардлыг чуулгын жил бүрийн төсөвт тусгаж баталж өгч байхыг Хотын санхүүгийн хэлтэс /н.Гонгор/-т зөвшөөрсүгэй.

7. Чуулгыг энэ оны IY улиралд багтааж албан хэрэгчээний телефон утастай болгох арга хэмжээ авахыг Хотын телефон, радио ашиглалтын хороо /н.Банзрагч/-д даалгасугай.

8. Хотын эстрадын дуу бүжгийн чуулгыг ижил төрлийн чуулга /музикхолл/-тай ажил төрлийн холбоо тогтоож туршлагыг нь судлаж ажиллах асуудлыг 1989-1990 оны гадаад арга хэмжээний телевизөөнд тусгаж хэрэгжүүлэхийг боловсон хүчин н.Туяа, Хотын соёлын хэлтэс /н.Бизъяа/-т даалгасугай.

9. "Улаанбаатарын уянга" чуулгыг "Ялалт" кино театрын байранд түр байрлуулсугай. Үүнтэй холбогдуулан кино театрын ерөө, танхимын ашиглалтад зохицуулалт хийж чуулгын уран бүтээлчдийн хичээл сургуулийг, бусад үйл ажиллагаанд шаардлагатай ерөөгөөр хангаж өгөхийг Хотын соёлын хэлтэс /н.Бизъяа/-т үүрэг болгосугай.

10. Эстрадын дуу бүжгийн чуулга байрлах болон хотын хэмжээний соёл хүмүүжил, урлаг уран сайхны төвлөрсөн арга хэмжээ зохиож байх концертын заалын зураг төсвийг хийлгэж ойрын жилүүдэд бариулах асуудлыг холбогдох газарт тавьж шийдүүлэхийг Хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны орлогч дарга н.Төлеубайд үүрэг болгосугай.

11. Хотын соёлын хэлтэст одоо хуваарилаж байгаа орон сууцны тоог нэмэгдүүлэх замаар эстрадын дуу бүжгийн чуулгын жүжигчид, ажилтан, ажилчдыг орон сууцаар хангах, ахуй нөхцөлийг нь сайжруулах арга хэмжээ авахыг Хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны орлогч дарга н.Энэбиш, Соёлын хэлтэс /н.Бизъяа/-д даалгасугай.

12. БНМАУ-ын Соёлын яамны орлогч сайд н.Нарантуяад ДААЛГАХ нь: а/Хотын эстрадын дуу бүжгийн чуулга/музикхолл/-ын жижүжигчдийн улс төр, онолын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх зорилгоор

дуу хөгжим, бүжгийн жүжигчдийн курс хичээллүүлэх, улсын мэргэжлийн шалгалтанд оруулах;

б/Чуулгын уран бүтээлийн ажил, өдөр тутмын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, боловсон хүчнээр хангах, давтан сургаж байх асуудлыг жил бүрийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх;

в/Чуулгын уран бүтээлд шаардагдах гэрэл, тайз, хувцасны материал, чимэглэл, хөгжмийн зэмсэг ашпаратур, тоног төхөөрөмжөөр хангаж байх;

13. Эстрадын дуу бүжгийн чуулга /мюзикхолл/-д ДААЛГАХ нь:

а/Уран сайхны соёлын хэрэглээний нэр төрлийг олшруулж, уран бүтээл, тоглолт, үзэгчид, орлогын төлөвлөгөөгөө борлуулж хянах, батлах, Шилээлтийг нь зохион байгуулах замаар үйл ажиллагаагаа тогтмолжуулж 1991 оноос аж ахуйн тооцоонд бүрэн шилжих;


б/Улс хотын шугамаар зохиогдох соёл, уран сайхны төвлөрсөн арга хэмжээнд уран сайханчид, идэвхтнүүдийг ергөн оролцуулж байхын тулд сургалт-туршилтын студийг байгуулж ажиллах;

в/Манай орны болон ах дүү социалист орнуудын мэргэжлийн театр чуулгуудын туршлагаас бүтээлчээр суралцаж уран сайхны соёлын хэрэглээний шинэ төрөл болсон мюзикхоллыг хөгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх, түүнд мэргэжлийн уран бүтээлчдийн хүчийг хандуулахад үзэл суртал, хүмүүжил, зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсүгэй.




БИМАУ-ЫН СОЁЛЫН ЯАМНЫ
САЙД Б.СУМБЯА

[Handwritten signature]



УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ДАРГА

[Handwritten signature]
С.МӨНХЖАРГАЛ



БНМАУ-ын Соёлын яамны коллегий, Улаан-баатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны 1988 оны...дугаар сарын...ны өдрийн ...дугаар тогтоолын I дүгээр хавсралт

ХОТЫН ЭСТРАДЫН ДУУ БҮЖГИЙН ЧУУЛГА /МЮЗИКХОЛЛ/-ЫН ОРОН ТОО, ЦАЛИНГИЙН СХЕМ

д/д	Орон тооны нэгж	тоо	сарын чалин	жилийн цалингийн фонд /мян.төг/
<u>Нэг. Уран бүтээлийн нэгж</u>				
1.	Уран сайхны удирдагч, дарга	I	900-950	11,1
2.	Ерөнхий найруулагч	I	850-875	10,4
3.	Балетмейстер	I	750-850	9,6
4.	Хөгжмийн зохиолч, удирдаач	I	750-850	9,6
5.	Тайз, хувцас, реклам чимэглэлийн зураач	I	750-800	9,3
6.	Концертмейстер	I	600-700	7,8
7.	Туслах найруулагч	I	600-700	7,8
8.	Хөгжимчид	18	450-700	124,2
	Үүнд: Органист /Ф-но/	I		
	Гитар	3		
	Ударист	I		
	Саксофонч	2		
	Труба	2		
	Тромбон	I		
	Флейта	I		
	Хийл /виолончел/	6		
	Техникч-хөгжимчин	I		
9.	Бүжигчин /эм 8 + эр 8/	16	450-700	110,4
10.	Дуучин /эм 2 + эр 2/	4	450-700	27,6
11.	Циркийн жүжигчин	2	450-700	13,8
12.	Хөтлөн тоглогч/конференцсе/	2	550-600	13,8
	БҮГД	49		355,4
<u>Хоёр. Үйлчилгээ, санхүү аж ахуй</u>				
1.	Зохион байгуулагч буюу боловсон хүчин	I	600-700	7,8
2.	Хөгжим, хувцасны эрхлэгч	I	450-500	5,7
3.	Ня-бо	I	600-700	7,8

4. Комендант-нярав	I	450-500	5,7
5. Билет худалдагч, кассчин	I	400-500	5,4
6. Билет шалгагч	4	280	13440
7. Бичиг хэргийн эрхлэгч, бичээч	I	400-450	5,1
8. Мушаан	I	400-500	5,4
9. Үйлчлэгч	2	260	6240
	БҮГД	I3	62,6

Турав. Техникийн ажилчин

1. Тайзны машинист	I	450-550	6,0
2. Тайзны ажилчин	2	350-400	9,6
3. Уран сайхны гэрэлтүүлэгч-техникч	I	450-500	5,7
4. Гэрэлтүүлэгч	2	400-450	10,2
5. Дууны найруулагч/оператор/	I	450-500	5,7
	БҮГД	7	37,2

ТАЙЛБАР

- 1. Уран бүтээлийн багш 7 хүний цалин 65,6 мян.төг
 - 2. Жижигчин 42 хүний цалин 289,8 мян.төг
 - 3. Үзвэр үйлчилгээ, санхүү аж ахуйн 13 хүний цалин 62,6 мян.төг
 - 4. Техникийн 7 хүний цалин 37,2 мян.төг
- Нийт 69 нэгжийн цалингийн фонд 455,2 мян.төг
Цалингийн шимтгэл 43,2 мян.төг